

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

СЭТГҮҮЛЧИЙН ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖ, МЭДЭЭЛЭЛ АВАХ,
ТҮГЭЭХДЭЭ ГАРГАЖ БУЙ ЁС ЗҮЙН АЛДАА

Л.Ариун*, Б.Энхрийшагай**

*ХУИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

**ХУИС-ийн сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн докторант

Түлхүүр үгс: медиа харассмент, сэтгүүлчийн ёс зүйн зөрчил, хүний эрхийн мэдрэмж

Мэдээллийн хэрэгсэл хүчирхийллийн шалтгаан болж, амьдралд гардаг олон гэмт хэрэг хэвлэлийн мэдээллээс санаа сэдэл авсан байдаг тухай мэргэжилтнүүд хэлдэг. Энэ нь тухайн сэдвийг мэдээлж сурвалжлахдаа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага мэргэжлийн алдаа гаргаж, хүний эрхийн мэдрэмжгүй, ёс зүйгүй ажилласны үр нөлөө. Өөрөөр хэлбэл энэ эмзэг сэдвийг мэдлэгтэй, мэдрэмжтэй биш, зөвхөн дуулиан шуугиан болгож мэдээллэх нь ийм сөрөг үр дагавар авчирдаг гэдгийг сэтгүүлч хүн бүр ойлгож ухамсарлах шаардлагатай. Мөн хэвлэл мэдээлэл “хүчирхийллийг мэдээлэхдээ өөрөө хүчирхийлэл үйлдэж байна” хэмээн олон нийтийн зүгээс шүүмжлэл ирдэг. Сэтгүүлч эх сурвалжаасаа асуулж буй асуулт илт дээрэнгүй өнгө аястай байх, хохирогч, сэжигтний дүрсийг өөрөө хүсэхгүй байхад

ил тодоор үзүүлэх түүнчлэн гэмт хэргийн хар бараан мэдээг тогтмол, ихээр үзүүлэх нь ч өөрөө дарамт хүчирхийлэл болдогийг анхаарах нь зүйтэй. Цаашлаад эх сурвалжаас хүчээр ярилцлага авах, хүсээгүй байхад нь зураг авч бичлэг хийж үүнийгээ “хэвлэлийн эрх чөлөө”, “олон нийтийн мэдээлэл авах эрх” хэмээн хайцаалж микрофон, камер барин дайрах, элдэн хөөх нь түгээмэл болох хандлагатай. Энэхүү судалгаагаараа хэвлэл мэдээлэл эх сурвалждаа болон хэрэглэгч олон нийтдээ дарамт үзүүлнэ гэж юуг хэлээд байгаа хийгээд сэтгүүлчийн ёс зүйн хүрээнд хэрхэн ажиллах ёстой вэ гэдгийг онол, арга зүйн үүднээс авч үзэв. Түүнчлэн манай сэтгүүлчид, хэвлэл мэдээлэл ямар сэдэв, агуулга дээр ёс зүйн алдаа гаргаж, хэрэглэгч олон нийтэд дарамт, хүчирхийллийн шинж чанар үзүүлж байгааг гаргах гэж зорьлоо.

Англи хэлний harassment гэх үг нь Монгол хэлэнд harass буюу дарлах, хүчирхийлэх, зовоох гэдэг үйл үгийн нэршил, нэр үг байдлаар

бууж байна. Энэ үгийг Монголын хууль зүйн тогтолцоонд 2011 оноос эхлэн дарамт гэдэг утгаар хэрэглэж ирсэн. Тус онд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдаж, энэ хуульд sexual harassment гэх ойлголтыг бэлгийн дарамт гэдэг утгаар оруулжээ.

Тэгвэл harassment буюу дарамт, хүчирхийлэл гэх үгийг өнөө цагт олон улсад бэлгийн дарамтаас гадна социал медиа дарамт, хэвлэл мэдээлэлд төрөөс үзүүлэх дарамт гэх зэрэг өргөн агуулгаар хэрэглэж байна. “Хэвлэл мэдээллийн дарамт” гэх ойлголтын хүрээнд төр засгаас хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах, дарамтлах оролдлого болон хэвлэл мэдээллийн зүгээс бусад талуудад үзүүлэх дарамт гэсэн хоёр утгаар хэрэглэж байна. Тухайлахад “Дөрөв дэх засаглалд чиглэсэн хүчирхийлэл: Африк дахь медиа харассментийг тайлбарлах нь” эрдэм шинжилгээний өгүүлэлд зохиогч Петер Вон Доепп, Даниел Ж.Янг нар хөгжиж буй орнуудад төр засаг нь хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд оролцож байгаа нь ардчилалд учруулж буй нийтлэг аюул заналхийлэл (Петер Вон Доепп & Даниел Ж.Янг, 2013) гэж үзжээ. Ингээд Африк тив дэх засгийн газрууд он цагийн явцад мэдээллийг хянах гэж оролдсон тохиолдлуудын ард ямар шалтгаан байсныг тогтоохыг оролдсон байна. Тэд засгийн газар эрх мэдлээ хадгалах, нэмэгдүүлэх гэж оролдлого гаргах бүрд хэвлэл мэдээллийн салбарыг дарамтлах үйл явдлууд болдог гэх таамаглал дэвшүүлж 23

улс орон, 15 жилийг хамарсан өргөн цараатай судалгаа хийсэн. Судалгааны дүнд томоохон жагсаал тэмцэл, төрийн эрхийг хүчээр авах оролдлого, хямрал зөрчилдөөн үүсэх бүрд, мөн засгийн газар улс орныхоо Үндсэн хуулиа өөрчлөхийг завдах үед төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэл рүү чиглэсэн дарамт нэмэгддэг болохыг тогтоожээ.

Медиа харассмент шинэ ойлголт биш бөгөөд энэ тухай эрдэм шинжилгээний өгүүллүүд цөөн боловч нийтлэгдсэн байна. Английн гүнж Диана агсан *папараци* гэрэл зурагчдад хөөгдөж явах үедээ осолдож, амь насаа алдсан явдлаас эхлэн энэ асуудлыг хүчтэй хэлэлцэж эхэлсэн ба энэ эмгэнэлт үйл явдлын дараа Их Британид, түүнээс өмнө АНУ-д, цаашлаад европын улс орнууд хувь хүний нууцыг хамгаалах, бүхий л төрлийн дарамт, хүчирхийллээс ангид байх тухай хуульдаа өөрчлөлт оруулжээ.

Папараци гэрэл зурагчдаас үүдэлтэй харассмент гэх энэ ойлголт хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн, яаж холбогдож байгааг авч үзвэл. Нэгдүгээрт, эдгээр гэрэл зурагчдын ихэнхдээ хууль зөрчиж, бусдын эрхэнд халдаж авсан гэрэл зургийн бүтээлийг хэвлэл мэдээллийн байгууллагууд худалдаж аваад хэвлэн нийтэлдэг. Хоёрдугаарт, папараци зурагчдын гаргадаг ёс зүйгүй, хүний эрхийн мэдрэмжгүй, ашиг хонжооны төлөөх, хууль зөрчсөн энэ үйлдлийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд тэр дундаа мэргэжлийн сэтгүүлчид гаргадаг болсон нь маш их шүүмжлэлд өртдөг.

Сонирхол татсан зураг, мэдээ олох гэж хөөцөлдөх хэвлэлийнхэн, папарациуд болон олны танил хүмүүсийн хувийн амьдралаа хамгаалах хүсэл мөнхөд зөрчилддөг. Энэхүү ашиг сонирхлын зөрчил нь бүр гүнзгийрч олны танил хүмүүсийн бие махбодын аюулгүй байдлын (эрүүл мэнд, амь нас) хэмжээнд яригдах болов. Судлаач Патрик Ж.Алах алдартнуудын хувийн нууцыг хамгаалах арга замыг санал болгосон байдаг (Patrick J. Alach, 2008). Өөрөөр хэлбэл тухайн алдартан өөрийг нь алдартай болгосон тэрхүү олон нийтийн өмнө нээлттэй дүрийнхээ (public role) үүргийг гүйцэтгэж байгаа бол зургийг нь дарж болно. Харин бусад тохиолдолд мэдээ болохоор үнэ цэнтэй эсэхэд шалгуур тавих нь зүйтэй гэж үзжээ. Цаашлаад алдартай хүмүүсийн энгийн өдөр тутмын амьдралын талаар зураг дарахыг хориглох, энэ зургийг худалдаж авч нийтэлж байгаа ХМХ-д ёс зүйн шаардлага тавих зэрэг замаар ажиллах нь зөв юм хэмээсэн. Шүүх байгууллага ч энэ хэргийг шийдэхдээ тухайн хүнийг алдартай болгосон үйлдлийг сурвалжилж байна уу (жишээ нь жүжигчин хүн бол кинотой холбоотой үйл ажиллагаа эвентэд оролцох үед зөвшөөрнө) мөн тухайн зургийг авах бусад үнэ цэнтэй шалтгаан байсан уу гэсэн үндэслэлүүд дээр тулгуурлаж шийдвэр гаргадаг аж. Олны танил хүмүүсийн тухай ХМХ-д нийтлэгдэх нь зайлшгүй боловч тэд ч гэсэн хуулиар хувийн нууц, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэйг мартаж болохгүй гэдгийг сануулах нь зүйтэй юм.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн ёс зүйн хүрээнд энэ асуудлыг хэрхэн зохицуулж ирсэнийг олон улсын туршлагаас авч үзвэл. Хэвлэлийн эрх чөлөө хамгийн өндөр хөгжсөн 10 улсын жагсаалтад 2013 оноос хойш тогтмол багтдаг Швед улсын хувьд (2021 онд гуравдугаар байрт жагссан) хуулиараа хэвлэл мэдээллийн эрх чөлөөг маш сайн зохицуулсан орны тоонд ордог. Үндсэн хууль болон хэвлэлтэй холбоотой бусад хуулиудад хэвлэл мэдээлэл нь өөрсдийн хүссэн байдлаар үзэл бодлоо илэрхийлж, өөрсдийн сонирхолтой гэж үзсэн сэдвээрээ нийтэлж нэвтрүүлэхийг зөвшөөрсөн байдаг байна. Харин хэвлэл мэдээллийн бүх байгууллагын үйл ажиллагааг ёс зүйн нэгдсэн кодоор зохицуулдаг. Энэ ёс зүйн код нь ХМХ-ийн агуулгыг цензурдэх биш харин ард иргэд, хувь хүмүүсийг хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны нөлөөгөөр зовох, хохирохоос сэргийлэх тухай заасан байдаг. Шведийн ХМХ-ийн ёс зүйн кодоод “ХМХ нь тухайн сэдэвт чухал ач холбогдолгүй бол хэн нэгэн хувь хүний гарал үүсэл, хүйс, үндэстэн, албан тушаал, улс төрийн үзэл бодол, шашин, бэлгийн чиг баримжааны талаар онцлохгүй, энэ мэдээллийг тодруулахгүй” (Emilia Lindholm Fjeld, 2021) гэж заажээ.

Их Британийн сэтгүүлчдийн ёс зүйн кодын 2-р зүйлд хувь хүний нууцын тухай, 3-р зүйлд харассментийн тухай ийн оруулсан байна (ИБУИНВУ-ын Редакторуудын хорооноос баталсан

Редакторуудын ёс зүйн код, 2021).

Хувь хүний нууц

- i) Хүн бүр хувийн болон гэр бүлийн амьдрал, орон гэр, биеийн болон сэтгэцийн эрүүл мэнд, харилцаа холбоо, дижитал харилцаа холбооны нууцаа хамгаалуулах, хүндлүүлэх эрхтэй.
- ii) Редакторууд ямар ч хүний хувийн амьдралын тухай мэдээллийг тэдний зөвшөөрөлгүй гаргахаас сэргийлэх үүрэгтэй. Зөвхөн тухайн хүн өөрөө хувийн мэдээллээ олонд дэлгэсэн, мөн энэ мэдээлэл нь олон нийтийн дунд аль хэдийн тархсан тохиолдолд зөвшөөрөлгүйгээр ашиглана.
- iii) Хувь хүний зургийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр олон нийтийн болон хувийн эзэмшил газар дарахыг хүлээн зөвшөөрч болохгүй.

Харассмент-Дарамт үзүүлэх

- i) Сэтгүүлчид мэдээлэл авахдаа бусдыг айлган сүрдүүлж, дарамталж болохгүй.
- ii) Сэтгүүлч тухайн хүн нэг удаа л татгалзсан бол үргэлжлүүлэн асуулт тавих, утсаар холбогдох, араас нь хөөж, зургийг нь дарж болохгүй. Мөн эзэмшил газраас нь явахыг хүссэн шаардлага тавихад явахгүй байх, тухайн хүний араас дагахыг хориглоно. Шаардлагатай тохиолдолд өөрийгөө болон төлөөлж буй хэвлэл мэдээллийн байгууллагаа танилцуулна.
- iii) Редакторууд өөрийн удирдлагад ажиллаж байгаа хүмүүс дээрх зарчмыг зөрчиж олж авсан мате-

риалыг хэвлэхгүй байх хариуцлага хүлээнэ.

Гэхдээ олон нийтийн эрх ашгийн үүднээс зарим тохиолдолд дээрх зарчмыг хэрэгсэхгүй байж болно гээд олон нийтийн эрх ашиг гэдэгт дараах ойлголтуудыг хамруулж үзжээ.

- Болзошгүй гэмт хэрэг, онц ноцтой нөхцөл байдлыг мөрдөх, илчлэх
- Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс
- Олон нийтийг буруу ойлголт авахаас хамгаалах
- Хувь хүн, эсвэл байгууллагыг хүлээсэн үүргээ биелүүлэхдээ алдаа гаргасан эсвэл биелүүлж чадахгүй байгааг дэлгэх.
- Шударга ёсны эсрэг үйлдлийг дэлгэх
- Олон нийтийн дунд үүссэн маргаантай байдлын сэдвийн талаар ойлголт өгөх
- Нууц хуйвалдааныг дэлгэх (Editor's Code of Practice)

Сэтгүүлчийн өдөр тутмын ажил, үйлдэл нь хүний хувийн орон зай, хувийн нууцтай өргөн утгаар холбогдож байдаг. Сэтгүүлч мэдээлэл цуглуулахдаа, мөн цуглуулсан мэдээллээ нийтэлж, нэвтрүүлэхдээ бусдын хувийн нууцад санаатай болон санаандгүйгээр халдах тохиолдол гарна. Мөн хүнийг дургүй байхад нь отож байгаад ярилцлага авах аргыг ашигласан бол ёс зүйн зөрчил болно. Иймээс өдөр тутамдаа мэргэжлийн ёс зүйн кодоо л сахин баримтлах нь мэргэжлийн нэр хүндээ өргөх, шүүх цагдаад дуудагдахгүй байх, олон

нийтийн итгэлийг олох ганц арга зам юм.

Монголын сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбарт сэтгүүлчийн ёс зүй, хүний эрхийн зөрчил, мэдрэмжтэй холбоотой асуудлыг судлаачид, мэргэжилтнүүд тогтмол ярьж хэлэлцдэг, мэргэжлийн сургууль курст сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг өргөн хүрээнд үзэж судалдаг. Гэвч хүний эрхийн мэдрэмжгүй, мэргэжлийн ёс зүйн мэдлэг ойлголт муутай сэтгүүлчид хэвлэл мэдээллийн байгууллага олширч, олон нийтийн шүүмжлэлд ихээр өртөх болсон өнөөгийн байдлаа дахин нэг харж авч үзэх зайлшгүй шаардлага байна. Манай ТВ, видео сайтууд хүний нүүр царайг зөвшөөрөлгүй гаргах, хүсээгүй байхад нь ярилцлага авах, асуултаараа гутаан доромжилсон, дарамталсан өнгө аяс гаргах, нүүр царайг нь халхалсан ч ямар нэг байдлаар танигдахуйцаар үзүүлэх нь элбэг байна. Судалгаагаар ийм алдааг голдуу хууль зөрчсөн гэж үзэж буй иргэд, олны танил улс төр, урлагийн одуудаас яриа авахдаа гаргаж байгаа нь ажиглагдлаа. Тодруулбал, цагдаа нартай шөнийн сурвалжилга хийж байгаа сэтгүүлч, гэмт хэрэгтэнг илрүүлэн баривчилж буй цагдаагийн ажилтантай хамт тухайн хүнээ байцааж, нүүр царайг нь ил гаргаж, нэр усыг нь зарлан, асуулт бүр нь дарамталсан өнгө аястай байх нь ёс зүйн маш том алдаа төдийгүй тухайн хүнээ, ар талд нь байх гэр бүр, үр хүүхдийг нь нийгэмд давхар шийтгэж байгаа гэдгээ ойлгох нь чухал. Цагдаа нартай гэнэтийн баривчилгаа хийж

шөнийн сурвалжилга хийхдээ маш болгоомжтой байж анхааралтай ажиллах ёстой. Хэдийгээр тухайн хүн хууль зөрчсөн, гэмт хэрэг хийсэн нь үнэн боловч тухайн хэрэгт ямар ч хамааралгүй ар гэр нь ичгэвтэр байдалд ордог гэдгийг санаж байх ёстой. Америкт 1990-ээд оныг хүртэл цагдаа нар гэмт хэргийн газар очихдоо сэтгүүлч, хэвлэлийнхнийг дагуулдаг байдал түгээмэл байсан. Цагдаагийн дэргэд хэвлэлийнхэн ажлаа хийж, мэдээлэл бэлтгэх нь хүний хувийн өмчид халдсанд тооцогддоггүй байв. Гэвч АНУ-ын Дээд шүүхээс нэгэн заргыг шийдвэрлэхдээ цагдаа нар нэгжлэг хийх зөвшөөрөлтэй ирж, хүний хувийн өмчид нэвтэрсэн ч энэ нь сэтгүүлчдэд хамаагүй гэж үзсэн байна (Марк Саблеман, 1997). Цаашилбал нууц камер, дуу хураагч зэрэг төхөөрөмж ашиглах нь ч хууль бус гэж үзэж сэтгүүлч энэ мэтээр ямар ч арга ашигласан бай үүнийг эх сурвалжийн хувийн нууцад халдсан гэж үздэг. Тэр ч байтугай мэдээллийн эх сурвалж сэтгүүлчийг гэртээ, ажил дээрээ урьж ярилцлага өгөхийг зөвшөөрсөн ч сэтгүүлч нууц камер, дуу, дүрс хураагч ашигласан тохиолдолд зөрчил гэж үздэг аж.

NТН телевизийн шөнийн сурвалжилгуудад ёс зүйн зөрчил их байна. Тухайлбал, “Согтуугаар жолоо барьсан 60 орчим хүн өдөртөө эрхээ хасуулж байна” гарчигтай шөнийн сурвалжилгад цагдаатай хамт сэтгүүлч хотын зам дээрээс сурвалжилга хийж, хэмжигч үлээж байгаа хүн бүрийг дүрсийг бүдгэрүүлэлгүй гаргаж, сэтгүүлч энэ-

хүү дүрсэн дээрээ согтуугаар автомашин барьж эрхээ хасуулсан жолооч нарын тухай тоо баримт мэдээллээ. Дүрс солигдож жолооны ард суух нэгэн эмэгтэйг цагдаагийн албан хаагч дээрэнгүй өнгө аясаар *“Та яагаад согтуугаар тэврийн хэрэгсэл барьж байгаа билээ жолооч оо, Уранчимэг ээ”* хэмээхэд эмэгтэй эргэж харж камерын бичлэг хийж байгааг мэдээд нүүрээ буруулж *“За, та нар болиоч дээ, би ганц пиво уугаад харих гэж явсан”* гэж дургүйцэн хариулна. Энэ дүрс дээр эмэгтэйн нүүр царайг халхлаагүй бүрэн танигдаж байгаагийн дээр нэр усыг зарласан тул хэн гэдэг нь бүх талаараа танигдаж байлаа. Хамгийн гол нь мэдээний төгсгөлд сэтгүүлч *“Согтуугаар жолоо бариад баригдсан бол ядаж хариуцлагаа хүлээх хэрэгтэй. Саяны дүрс шиг хэвэ нэг ганц пиво уусан гэж хэлээд байдаг эмэгтэй хүн олон битгий байгаасай”* хэмээн өөрийн үзэл бодлоор дүгнэж байгаа нь хүний эрхийн, жендерийн мэдрэмжгүй, тухайн хүнийг буруутгах өнгө аяс шууд оруулсан, давхар шийтгэсэн гэх мэт ёс зүйн олон алдаа гаргажээ. Мэдээж хэрэг тухайн эмэгтэй ямар нэгэн байдлаар согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо барьсан нь тогтоогдсон бол зохих шийтгэлээ хүлээх нь тодорхой, гэвч хэвлэл мэдээлэл хүнийг давхар шүүж, шийтгэж буруутгаж, ард нь байх гэм зэмгүй гэр бүлийг нь ичгэвтэр байдалд оруулж байгаагаа ойлгох нь чухал байна. Тухайн хүний хувьд ичмээр, нэр хүндэд нь халдсан мэдээллийг үнэн байсан ч цацахгүй

байх нь ёс зүйд нийцнэ. Энэ мэдээлэл нь олон нийтийн эрх ашгийг зөрчөөгүй, тэдний зайлшгүй мэдэх шаардлагатай зүйл биш. 1942 онд болсон нэгэн явдал бусдын эрх, эрх чөлөөнд хэвлэл хэрхэн халдсан, үүнийхээ хариуцлагыг хэрхэн хүлээсэн тухай кейс юм. “Тайм” сэтгүүлд Дорот Барбер гэгч идэх эмгэгтэй бүсгүйг Канзас хотын эмнэлгийн өрөөнд байхад зургийг нь зөвшөөрөлгүй авсан нийтлэл хэвлэгдсэн байна. Ихэд өлсөж, идэхээ зогсоож чаддаггүй энэ эмэгтэйн тухай нийтлэлийг “Starving Glutton” буюу “Өлсөж үхэж буй глютен” гарчигтай хэвлэн, арван хүний дайтай хоол иддэг гэх мэтээр бичиж, зөвшөөрөлгүйгээр зургийг нь авч нийтэлсэн аж. Хэдий эдгээр мэдээлэл нь үнэн бодит боловч тухайн хүний эрүүл мэндийн байдлыг дэлгэх нь эрхийг нь зөрчиж буй явдал гэж үзэн, энэ баримтад тулгуурлан Миссури мужийн шүүхээс хэвлэлийг буруутгажээ. Сүүлийн жилүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн байдал, гоо сайхны мэс заслын тухай, үр шилжүүлэн суулгах эмчилгээ зэрэг нь хүний эрүүл мэндийн байдал гэсэн хэсэгт орж хувь хүний нууцад хамаарах болсон.

Түүнчлэн хувцасгүй нүцгэн байгаа, бэлгийн чиг баримжааг илчилсэн, хүний бүтэлгүйтийг дэлгэсэн мэдээлэл нь ч хүний эрхийн зөрчил, хэвлэл мэдээллийн дарамтад тооцогдоно. Хүмүүс нэр нүүрээ гаргахын зөвшөөрөхгүй бол бүх талаар танигдах байдлыг нуух ёстой. Үүнийг олон улсад хувийн өгөгдөл хамгаалах хуулиар зохи-

цуулдаг. Эх сурвалж өөрөө зургаа гаргахыг зөвшөөрсөн ч гэсэн гарч болох үр дагаврыг сайтар тайлбарлаж ойлгуулсны үндсэн дээр зөвшөөрлийг нь албан ёсоор буюу бичгээр аваарай. Ингэхдээ зураг, дүрсийг нэрээ нууцалсан, танигдуулахгүй байдлаар авах, эсэхийг мөн тодорхой ярилцаж тохирох хэрэгтэй ("Жендерийн мэдрэмж-Ёс зүйтэй сэтгүүл зүй" редакцуудад зориулсан удирдамж) гэсэн агуулга ёс зүйн кодуудад ч бий.

Ажиглалтын судалгааг хийхдээ телевиз, сайтуудын "Шөнийн сурвалжилга"-ыг голчлон авч үзсэн. Шөнийн сурвалжилгын сэдвийн дийлэнх нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, биеэ үнэлэлт, хар тамхины хэрэглээ, мөрийтэй тоглоомын газар гэх зэрэг гэмт хэргийн тухай мэдээлдэг юм байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг, хууль зөрчигчдийн талаар мэдээлэл бэлтгэхдээ хэвлэл, сэтгүүлчид илүү түрэмгий өнгө аястай байдаг нь ажиглагдлаа. "Хууль зөрчсөн бол хэн ч түүнийг яаж ч болно", "биеэ үнэлдэг бол ямар ч сэтгүүлч, хэвлэл ороод юу ч асууж болно" гэсэн ойлголт хандлага сэтгүүлчдэд байна уу даа хэмээн дүгнэхээр байна. Бодит байдлыг сурвалжлан мэдээлэхдээ хэнийг ч ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл буруу ойлголтын золиос болгохгүй байх нь хэвлэл мэдээллийнхний мэргэжлийн, ёс зүйн шаардлага юм. Гэвч Монгол төдийгүй дэлхий даяар сэтгүүл зүйн салбарынхан жендерийн хэвшмэл ойлголтыг халах, ялангуяа жендерт суурилсан хүчир-

хийллийг мэдээлж, сурвалжлах тал дээр ёс зүйн алдаа гаргах тохиолдол элбэг ("Жендерийн мэдрэмж-Ёс зүйтэй сэтгүүл зүй" редакцуудад зориулсан удирдамж). Гэмт хэргийг хэрхэн мэдээлэх тухай мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, сэтгүүлчийн ёс зүйн зарчмууд тодорхой бий. Хүчирхийлэл, биеэ үнэлэлт, согтуугаар тээврийн хэрэгсэл барих зөрчил, хар тамхи, мансууруулах бодисын тухай, мөрийтэй тоглоомын газар гэх мэт гэмт хэргийн сэдэв бүр мэдээлэх өөр өөрийн онцлог, өнцөг, арга барилтай. Буруугаар мэдээлбэл хохирогчийг давхар хохироох, гэмт хэрэгтнийг өөгшүүлэх, нийгмийн сэтгэл зүйд буруугаар нөлөөлөх, цаашлаад хэвлэл мэдээлэл сэтгүүл зүйд итгэх иргэдийн итгэл үгүй болох гээд маш өргөн хүрээний хор уршигтайг байнга анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ сэдвүүдээр мэргэшсэн, ёс зүйтэй сэтгүүлч, редакцууд нийгмийн тулгамдсан асуудлын хүрээнд сурвалжилга хийж цаад суурь учир шалтгааныг нээн илрүүлэх зарчмаар асуудлыг хөндөх ёстой. Гэтэл манай хэвлэл мэдээллүүд дээрх эмзэг сэдвийг зөвхөн сенсац хөөх, хандалт авах зорилгоор мэдээлж байгаа байдал хэтэрхий их байгаад асуудлын учир байна. Биеэ үнэлэлтийг нийгмийн олон талт үзэгдэл гэдгийг харуулж, энэ гэмт хэргийн цаана ашиг олж байгаа, худалдан авч байгаа хүмүүсийг гаргахгүй тухайн үед цагдаад баригдсан хэдэн охид эмэгтэйчүүдийг чичилсэн маягаар мэдээлэх нь их. Биеэ үнэлэлтийн хэрэгт орооцолдсон эмэгтэйчүүд хүн

худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогч байх нь элбэг. Тийм учир энэ байдлыг ялгаж салгаж мэдээлэх нь маш чухал. Энэ хүмүүсийг шууд буруутгасан дайрсан маягаар мэдээлэх нь цаана нь жинхэнэ гэмт хэрэгтэн илрэхгүй үлдэх, мөн олон хохирогч ийм маягаар давхар шийтгүүлэх юм байна хэмээн цагдаад илчлэхээс татгалдаг олон уршигтай. Гэтэл NTN ТВ, ТВ6, Arslan.mn, ТВ4, Zarig.mn, Daam.mn, Папараци.мн зэрэг мэдээллийн сайтуудын биеэ үнэлэлт, хүчингийн хэргийн талаарх сурвалжилгад тухайн хүн нүүр царайгаа гаргахын хүсэхгүй байхад хүчээр дүрс бичлэг хийх, яриа авах /нөгөө хүн нь нүүрээ нуух, буруу харах, юмны араар орох, ярихыг хүсэхгүй байх/ хүний нэр, зүс царайг далдлахгүйгээр ил гаргах, сэтгүүлч дарамталсан, буруутгасан өнгө аясаар асуух маягаар үзүүлж байна. Тухайлбал “Өөр ажил хийхгүй яагаад ийм амар хялбар маягаар мөнгө олох гэж байгаа юм бэ”, “Өдөрт хэдэн хүнтэй унтдаг уу”, “Нэг унтахдаа хэдэн төгрөг авдаг

уу”, “Хэдэн жил биеэ үнэлж байна?” гэх зэрэг үг хэллэг, хандлагаараа шууд буруутгасан өөрийн үзэл бодлоо тулгасан, загнасан, шүүмжилсэн, шийтгэсэн өнгө аятай асуулт асууж хариулахыг шаардаж байгаа нь “хэвлэл хүчирхийллийг мэдээлэхдээ өөрөө хүчирхийлэл үйлдэж байна” гэсэн дүгнэлтийг баталж байна. Энэ үзэгдэл өдгөө мэдээллийн видео сайтуудад түгээмэл болж камер, микрофоноо бариад хэн нэгнийг яриа өгөхийг хүсэхгүй байхад хөөн гүйх нь мэдээ авах шинэ арга барил мэт харагдаж залуу сэтгүүлчид ингэж мэдээлэл авах жинхэнэ мэргэжлийн хэв шинж гэж андуурах нь түгээмэл болжээ. Хүсээгүй байхад нь дүрсийг нь бичиж, яриа авах гэж хөөцөлдөх, яриа өгөөгүй нь төлөө өөрийн үзэл бодлоор дүгнэн буруушаах зэргээр ажиллах нь мэдээллийн сайтуудын лайвуудад бүр элбэг боллоо.

дүгнэн буруушаах зэргээр ажиллах нь мэдээллийн сайтуудын лайвуудад бүр элбэг боллоо. Zarig.mn зэрэг мэдээллийн сайтууд төрийн ордны коридорт хүлээж байгаад томоохон хурал зөвлөгөө гарч ирсэн албан тушаалтнуудаас мэдээлэл авах гэж оролддог. Тухайн асуудлыг

«

“Хэвлэл хүчирхийллийг мэдээлэхдээ өөрөө хүчирхийлэл үйлдэж байна”. Ийм үзэгдэл өдгөө мэдээллийн видео сайтуудад түгээмэл болж камер, микрофоноо бариад хэн нэгнийг яриа өгөхийг хүсэхгүй байхад хөөн гүйх нь мэдээ авах шинэ арга барил мэт харагдаж залуу сэтгүүлчид ингэж мэдээлэл авах жинхэнэ мэргэжлийн хэв шинж гэж андуурах нь түгээмэл болжээ. Хүсээгүй байхад нь дүрсийг нь бичиж, яриа авах гэж хөөцөлдөх, яриа өгөөгүй нь төлөө өөрийн үзэл бодлоор дүгнэн буруушаах зэргээр ажиллах нь мэдээллийн сайтуудын лайвуудад бүр элбэг боллоо.

»

эцэслэн шийдвэрлээгүй, хэвлэлд энэ тухай мэдээлэл өгөх болоогүй тухай албан тушаалтан тайлбарлаад мэдээлэл өгөх боломжгүй гээд бай-хад л “мэдээлэл өгөөч”, “яагаад ө-гөхгүй байгаа юм”, “ийм таамаг байна үнэн үү” гэх мэтээр ээрч, хөөцөлдөх ёс зүйгүй үйлдэл. Бүүр цаашилбал улс орны хэмжээний томоохон асуудлын хувьд эцэслэн шийдвэрлэгдээгүй үед үзэгчдэд дутуу дулимаг, буруу зөрүү мэдээлэл өгөх эрсдэл-тэй гэдгийг анхаармаар.

Ямарваа нэгэн үйл явдал асуудлын талаар хэрхэн яаж мэдээлбэл олон нийт зөв ойлголт авч, зөв зүйтэй шийдвэр гаргаж хүлээж авч оролцох вэ гэдгийг шийдэж байж олон нийтэд хүргэдэг. Сэтгүүлч ч тухайн асуудлыг олон талаас нь нягталж байж олон түмэнд хүргэх ёстой гэдгээ мэдэж хурал болгон, сэдэв болгон дээр эх сурвалжийг хүсээгүй байхад нь санал сэтгэгдлийг сонсох гэж оролдох нь мэргэжлээрээ түрүү барьж дайрч байгаа дарамт гэж үзэж болно. Түүнчлэн хувийн орон зайд халдан кафед кофе уугаад хүнтэй ярилцаж байхад нь камер, микрофон барьж очих, араас нь хөөх гэх мэтээр мэдээлэл авах нэрээр хүчирхийлэл, дарамтын шинж чанартай ажиллах нь түгээмэл болоод байна. Нэг хүний тухай мэдээлэх, түүнээс мэдээлэл авах гэж хөөцөлдөхдөө ард нь байгаа үр хүүхэд, тэдний нийгмийн амьдралыг огт ойшоодоггүй нь дээрх жишээнүүдээс харагдаж байгаа юм. Нөгөө талаар манай төрийн албан тушаалтнууд, урлаг соёлын одууд бусад эх

сурвалжууд хэвлэл мэдээлэлтэй хэрхэн харилцахаа, тэд мэдээлэл авахдаа өөрийнх нь эрхийг зарим талаараа зөрчиж байгаа гэдгийг мэддэггүй. Үүнээс үүдэн хэвлэл мэдээллийнхэн яаж ч болно гэсэн ойлголт хандлагатай болчихдог мэт, микрофон бариад явахаараа эрх мэдэлтэй болсон мэт ойлгож ажиллах нь өөрсдийгөө ч салбарын нэр хүндийг унагаж байгаа нь тохиолдол цөөнгүй. Видео мэдээллийн сайтууд ambush interview буюу отоож байгаад ярилцлага авах нь зарим цаг үеийн шинжтэй, шуурхай мэдээлэлд тохирох боловч бүхий мэдээллээ иймэрхүү маягаар бэлтгэх нь тохиромжгүй. Эх сурвалжаа бэлтгэлгүй санамсаргүй байхад нь ам алдлуулах, ярилцлага өгөх боломжгүй, хүсэхгүй байна хэмээн хэлж байхад бүдүүлэг маягаар дахин дахин асуух, даган хөөцөлдөж зэргээр ажиллах бүр их боллоо. Хүний хувийн эзэмшил газрын үүдэнд дээрээс лайв хийж отох, гэр бүлийн маргааны шүүх хурлыг хүлээх, хувийн энэ асуудлаар ярилцлага өгөх дургүй байгаа эх сурвалжийг микрофон, камера бариад араас нь дагах, болсон үйл явдлыг өөрийн үзэл бодлоор дүгнэх зэрэг мэргэжлийн бус байдлаар ажиллах нь их байгааг ийнхүү анхааруулж, хэлэлцэх нь судлаач бидний үүрэг билээ.

Гэхдээ мэргэжлийн, туршлагатай редакцууд дээрх алдааг харьцангуй бага гааргадгийг ажиглалтын судалгаагаар гарсан. МҮОНТ-ийн “Монголын мэдээ” суваг замын осол гэмтлийн талаар бэлтгэсэн шөнийн сурвалжилга, Монгол

ТВ-ийн “Монгол залуучуудын дунд хар тамхи хэрэглээ болсон уу?” шөнийн сурвалжилга, Ийгл ТВ-ийн тээврийн цагдаагийн албатай хамтран бэлтгэсэн шөнийн сурвалжилга нь хүний нүүр, царай харьцангуй бага гаргаж цагдаа болон албаны хүмүүсээс яриа тайлбар авсан, машин, гудамж талбай зэрэг ерөнхий дүрс үзүүлж, яриа авч байгаа эх сурвалжийг аль болохоор танигдахгүй болгон далдалж, маш товчхон гаргаж байсныг онцолж байна. Хар тамхины хэрэглээний талаар хийсэн “Монгол” ТВ ийн тодруулга график дүрс ихтэй, эфирээр гарч байгаа нууц камераар авсан дүрс нь зохиомол дүрс. Энэхүү дүрс дээрээ нууцаар бичсэн аудиог тааруулсан нь үзэгчдэд сонирхолтой ч хүний эрхийг зөрчөөгүй, ёс зүйгээ барин ажиллаж мэргэжлийн түвшинд бэлтгэсэн байна. Энэ бүхэн нь манайд цөөхөн байдаг мэргэжлийн редакцууд, сэтгүүлчийн үйл ажиллагаа билээ.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сард баталсан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана хэмээх 6-р бүлэгт “Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана” /6.1/, “Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно” /6.2/, “Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч

болохгүй” /6.3/, “Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй” /6.4/, “ Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй” /6.5/ (mediacouncil.mn) гэсэн заалтууд шөнийн сурвалжилгыг хийхэд баримтлах зарчим, мэргэжлийн ажлаа ёс зүйтэй хийхэд зүг чиг болох ёстой юм. Мөн зарчмын 2-р бүлгийн “Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй” хэсэгт 2.2-“Мэдээлэл олж авах бусад арга гэдэгт өөрийн болон байгууллагын нэрийг худал хэлэх буюу хэлэхгүй байх, дарамтлах, айлган сүрдүүлэх, сэтгэл санааны онцгой байдлыг ашиглах, нууцаар бичлэг хийх болон тагнаж чагнахыг хамаатуулна” гэсэн ёс зүйн заалт нь микрофон, камер, олон нийтийн мэдээлэл авах эрхийг урдаа бариад эрх мэдэлтэн болчихдог сэтгүүлчдэд хэм хэмжээг нь зааж өгсөн заалт байгаа юм.

Мэдээлэл авах, түүнийгээ түгээхдээ сэтгүүлчид эх сурвалждаа дарамт үзүүлж, нэр хүндэд нь халдаж байгаа нь ёс зүйгүй, хүний эрхийн мэдрэмжгүй, ашиг хонжооны төлөөх, хууль зөрчсөн үйлдэл. Энэ үйлдлийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд тэр дундаа мэргэжлийн сэтгүүлчид гаргаж байгаа нь наад захын ёс зүйн дүрмээ сахихгүй байна гэсэн үг ба хэвлэл мэдээллийн дарамт гэх ойлголт эндээс гарч ирж сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн нэр хүнд унаж, тэдэнд итгэх илтгэл жилээс жилд буурч,

цаашлаад олон арван хүмүүсийн нийгмийн хүрээлэл, гэр бүл ажил, одоо амьдарч буй орчинд сөрөг байдлаар нөлөө үзүүлж хохироож байна. Сэтгүүлч хууль зөрчигчдийн тухай мэдээлэхдээ ёс зүйн алдаа гаргаж буй нь түгээмэл байна. Хэвлэл мэдээллийн редакцын анзааргагүй үйлдэл, сэтгүүлчийн хүний эрхийн мэдлэг, мэдрэмжгүй байдал, мэргэжлийн ёс зүйгүй байдал нь жирийн ард иргэд, олон нийтийг хохироох, зовоох, буруу хэвшмэл ойлголтыг дэврээх, бусдын нэр хүнд, эрүүл мэндэд халдах зэрэг олон сөрөг хүчин зүйлсийн шалтгаан болдог гэдгийг ойлгох нь чухал байна.

Цаашид энэ ойлголтыг илүү гүнзгийрүүлэн судалж хэвлэл мэдээллийн дарамт мэдээллийн төрөлд илүү гарч байна уу эрэн сурвалжилсан, эсвэл улс төр, эдийн засаг, урлагийн салбарын тухай мэдээлэлд байна уу, түүнчлэн ямар хэвлэл мэдээллийн байгууллагад ийм үзэгдэл түлхүү байна, сэтгүүлчийн нас хийгээд хүйстэй ямар нэгэн хамаарал байна уу, сэтгүүл зүйн боловсрол, ёс зүйн ойлголттой хэр-хэн яаж холбогдож байна, нийгмийн бусад ямар шалтгаан байна гэдгийг дэлгэрүүлэн судлах шаардлага байна гэж үзлээ.

Эшлэл

1. Assaults on the Fourth Estate: Explaining Media Harassment in Africa. Peter VonDoepp , and Daniel J. Young. <https://www.journals.uchicago.edu/doi/abs/10.1017/S0022381612000850>
2. Paparazzi and Privacy Paparazzi and Privacy, Patrick J. Alach. 2008. <https://digitalcommons.lmu.edu/cgi/viewcontent.cgi?referer=&httpsredir=1&article=1535&context=elr>
3. “Taboo is something that the media should not engage in” Swedish journalists’ perceived freedom when reporting on controversial topics, Emilia Lindholm Fjeld Södertörn University | School of Social Sciences Journalism | Spring semester 2021. <https://www.diva-portal.org/smash/get/diva2:1563920/FULLTEXT01.pdf>
4. ИБУИНВУ-ын Редакторуудын хорооноос баталсан Редакторуудын ёс зүйн код. 2021.
5. [https://www.ipso.co.uk/editors-code-of-practice/ Editors’ Code of Practice](https://www.ipso.co.uk/editors-code-of-practice/Editors%20Code%20of%20Practice)
6. Марк Саблемен. 1997 он. Мэдээллийн эрин үе дэх харилцаа холбооны хууль. Ху 34-37.
7. “Жендэрийн мэдрэмж-Ёс зүйтэй сэтгүүл зүй” редакцуудад зориулсан удирдамж” <https://bit.ly/3w2JS5u>
8. “Жендэрийн мэдрэмж-Ёс зүйтэй сэтгүүл зүй” редакцуудад зориулсан удирдамж” <https://bit.ly/3w2JS5u>
9. <http://www.mediacouncil.mn/p/7>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. <https://legalinfo.mn/mn/detail/253>
2. "Is Everyone a Journalist?". American Journalism Review. October 1997. Archived from the original on June 13, 2010. Retrieved January 27, 2009.
3. McGreevy, Patrick (September 24, 2013). "Gov. Jerry Brown signs law protecting children of public figures". LA Times.
4. Assaults on the Fourth Estate: Explaining Media Harassment in Africa Peter VonDoepp , and Daniel J. Young <https://www.journals.uchicago.edu/doi/abs/10.1017/S0022381612000850>
5. Paparazzi and Privacy Paparazzi and Privacy, Patrick J. Alach. 2008. <https://digitalcommons.lmu.edu/cgi/viewcontent.cgi?referer=&httpsredir=1&article=1535&context=elr>
6. “Taboo is something that the media should not engage in” Swedish journalists’ perceived freedom when reporting on controversial topics, Emilia Lindholm Fjeld Södertörn

- University | School of Social Sciences
Journalism | Spring semester 2021.
<https://www.diva-portal.org/smash/get/diva2:1563920/FULLTEXT01.pdf>
7. <https://www.ipso.co.uk/editors-code-of-practice/> Editors' Code of Practice
 8. https://www.facebook.com/watch?ref=search&v=1429532543780524&external_log_id=7d784f28-c697-48f3-98eafac91e528c35&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 9. https://www.facebook.com/watch?ref=search&v=1459018290831949&external_log_id=e68cee2e-b14e-49de-8dcc-54c04a09ae94&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 10. https://www.facebook.com/watch?ref=search&v=620111105018251&external_log_id=e68cee2e-b14e-49de-8dcc-54c04a09ae94&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 11. https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=431704511714723
 12. https://www.facebook.com/watch?ref=search&v=315842392482554&external_log_id=e68cee2e-b14e-49de-8dcc-54c04a09ae94&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 13. <https://www.facebook.com/watch/?v=162264954439119>
 14. <https://www.facebook.com/watch/?v=238769701490566>
 15. https://www.facebook.com/watch/?ref=search&v=265816034570831&external_log_id=e002049e-7c9e-48cb-999f-3cb779d9e8c3&q=%D0%97%D0%B0%D1%80%D0%B8%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%B3%D2%AF%D0%B9%D0%B4%D1%8D%D0%B3%20%D1%81%D1%8D%D1%82%D0%B3%D2%AF%D2%AF%D0%BB%D1%87
 16. https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=307222617908006
 17. https://www.facebook.com/watch/?ref=search&v=3140995062583815&external_log_id=ce9c2036-7a54-4d95-8ef9-235394a5e12f&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 18. https://www.facebook.com/watch?ref=search&v=1183748625018974&external_log_id=e68cee2e-b14e-49de-8dcc-54c04a09ae94&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 19. https://www.facebook.com/watch?ref=search&v=383658775898836&external_log_id=e68cee2e-b14e-49de-8dcc-54c04a09ae94&q=%D1%88%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%81%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BB%D0%B6%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0
 20. "Жендэрийн мэдрэмж-Ёс зүйтэй сэтгүүл зүй" редакцуудад зориулсан удирдамж" <https://bit.ly/3w2JS5u>
 21. <http://www.mediacouncil.mn/p/7>

Summary

There has been public criticism of the way media reports on crime and violence is violence itself. The criticism is caused by following reasons as reporters' attitude and preconditioning when they question their sources and how they portray and show victims and possible suspects' images on the photo and video reports. Furthermore, it becomes media abuse and media violence towards the audience when the media covers and sensationalizes these types of dark and sensitive topics frequently and on a large scale in the name of alarming and

preventing the public from these crimes and so on.

Nonetheless, it's getting more common day by day that media workers commonly practice unlawful and unethical behaviors during the news-gathering process. It could be pressuring sources/public figures to give them an interview, harassing them during an ambush interview with a rolling camera and microphone literally without sources' content and apparent will to not be filmed in it. Still, the media workers protect their actions under the shield of media freedom law and the public right to be informed.

This paper aims to show theoretical and practical approaches

addressing what media harassment is when it comes to journalists/reporters causes fear to their news sources and audience, how to fix this issue based on journalism ethics, and what kind of topics lead media workers to violate journalism ethics and to harass sources and public based on case studies.

Understanding how one careless and unprofessional decision of media and journalist who doesn't have human rights knowledge, common sense, and professional ethics are becoming the reason for numerous negative social phenomena in the end that could harm ordinary citizens and the public in general and contribute to spread certain stereotypes and damage other's reputation, dignity, and health.